

**Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 03 дугаар хуралдаан:**

- “Гадаадын академи, их, дээд сургуульд элсэн суралцагчдыг сонгон шалгаруулах журам”-ын төслийг хэлэлцэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулах,

- “Урьдчилан сэргийлэх тасгийн ажлын чиг үүрэг, дундаж үзүүлэлт, дүгнэх заавар”-ын төслийг хэлэлцэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулах,

- Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2015 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцэн дахин нягталж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2 дугаар улиралд багтаан хүргүүлэх,

- “Монгол оронд тохиолддог гамшгийн төрөл бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй, эрсдэлийн үнэлгээг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд”-ийг хэлэлцэн гарын авлага хэлбэрээр эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

- Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд 1 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнтэй танилцав.